

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *LD* Л.ДЭЛГЭР

2023 оны.....сарын..... өдөр

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙРУУДЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ
АЖЛЫН УДИРДАМЖ
№06**

Нэг. Хяналт шалгалтын зорилго, үндэслэл

1.1.Дотоод хяналт шалгалтын /цаашид шалгалт гэх/ зорилго нь Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байр, Нийслэлийн Засаг захиргааны I, II, III, IV, V байр, Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн Драгон, Мишээл, Дүнжингарав салбар, Сэлбэ, Баянхошуу дэд төвийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх;

1.2.Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан “Өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангуулах, зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр зөвлөн туслахад оршино.

1.3.Шалгалтыг Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/727 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам” болон байгууллагын дотоод хяналтын журам бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн явуулна.

Хоёр.Шалгалтын төрөл, арга хэлбэр

2.1.Газрын даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу төлөвлөгөөт бус шалгалтыг Нийслэлийн Засаг захиргааны байранд биечлэн очиж, байр хариуцсан менежерүүдийн өдөр тутмын үйл ажиллагаа, төлөвлөгөө тайлан, холбогдох судалгаа, баримт бичгийн бүрдэл, хөтлөлт, мөрдөх дүрэм журам, норм норматив, стандартыг хэрэгжүүлж буй байдал зэрэгт урьдчилан боловсруулсан шалгуур үзүүлэлтийн дагуу хэсэгчилсэн хяналт шалгалтыг зохион байгуулна.

2.2.Шалгалтыг явуулахдаа ажиглах, ярилцлага хийх, судалгаа авах, баримт бичигтэй танилцаж судлах, харьцуулах, тулган баталгаажуулах, нэгтгэн дүгнэх аргыг ашиглана.

Гурав.Хяналт шалгалт хийх хугацаа, бүрэлдэхүүн, хамрах хүрээ

3.1.Шалгалтыг 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн ажлын 5 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэх ба ажлын хэсэг нь дараах бүрэлдэхүүнтэй байна.

Ажлын хэсгийн
ахлагч

Инженерийн, байгууламжийн
ашиглалт, үйлчилгээний
албаны дарга Л.Мөсчихэр

Гишүүд:

Үйлчилгээний ерөнхий менежер
Б.Ууганжаргал

Ахлах мэргэжилтэн Т.Азжаргал

Ерөнхий инженер Б.Батсүрэн

Хууль эрх зүй тогтоол шийдвэрийн
хэрэгжилт хариуцсан ажилтан
Ю.Хүслэн

Сүлжээний инженер, ХАБЭА
хариуцсан ажилтан Б.Жаргалсайхан

Халаалт, агаар сэлгэлтийн инженер
Б.Доржбалжир

Тооцооны нягтлан бодогч Б.Бямбаа

Нарийн бичиг:

Дотоод хяналт шинжилгээ-үнэлгээ
хариуцсан ажилтан Б.Ууганцэцэг

3.2.Тус шалгалтад Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байр, Нийслэлийн Засаг захиргааны I, II, III, IV, V байр, Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн Драгон, Мишээл, Дүнжингарав салбар, Сэлбэ, Баянхошуу дэд төв хамрагдана.

Дөрөв. Хяналт шалгалт явуулах

4.1.Ажлын хэсэг нь шалгалт явуулах байранд биечлэн очиж дараах ажлыг хийж гүйцэтгэнэ.

а/Байр хариуцсан менежерт шалгалтын удирдамж, шалгалт явуулах арга, хэлбэрийг танилцуулж, үйл ажиллагаа, ажлын үр дүн, нөхцөл байдлын талаарх мэдээллийг авна;

б/Шалгалтад бэлдэх шаардлагатай материалыг бэлэн болгохыг даалгана;

в/Ажлын шинэлэг арга хэлбэр, тэргүүн туршлага, оновчтой саналыг судалж үнэлэлт өгөх;

г/Байр хариуцсан менежерийн удирдан зохион байгуулах ур чадвар, манлайлал, ёс зүй, харилцааны соёл зэрэг асуудлаар ажилчдаас судалгаа авах;

4.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, баримт бичгийн стандарт, хөтлөх хэргийн нэрс, төлөвлөгөө, тайлан хуваарь боловсруулах талаар зааварчилгаа өгөх,

4.3.Шалгалтыг удирдамжид заасан хугацаанд бүрэн явуулна.

4.4.Шалгалтын явцад олж авсан мэдээллийг шалгалтын зорилгоос өөрөөр ашиглах, удирдлагаас өөр хүмүүст задруулахыг хориглоно.

4.5.Шалгуулж байгаа албан хаагч хяналт шалгалтын ажилд санаатай саад учруулсан, хөндлөнгөөс нөлөөлсөн, шаардлагатай баримт материалыг гаргаж өгөөгүй бол энэ талаар газрын даргад мэдэгдэн, тэмдэглэл үйлдэж шалгалтын материалд хавсаргана.

4.6.Шалгалтын бүрэлдэхүүнд орсон албан тушаалтан холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн акт, дүрэм журам, заавар стандарт, норм нормативийг урьдчилан бүрэн судалж танилцсан байна.

Тав. Хяналт шалгалтыг үнэлж, дүгнэх

5.1.Нийслэлийн Засаг захиргааны байр хариуцсан менежерийн үйл ажиллагаанд батлагдсан удирдамж, шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт шалгалтыг явуулахдаа шалгах чиглэл тус бүрт 0-100 оноо өгч, чиглэлийг дүгнэх үзүүлэлтийг боловсруулж, авбал зохих оноог 0-100 хүртэл оноогоор тооцож авсан бүх онооны нийлбэрийг шалгах чиглэл, үзүүлэлтийн тоонд харьцуулж шалгасан чиглэл, үзүүлэлт бүрийн дундаж оноог гаргана.

5.2.Шалгасан чиглэл бүрийн дундаж онооны нийлбэрийг, шалгах чиглэлийн тоонд харьцуулж, үнэлгээний нийт оноог үндэслэн дор дурдсан ерөнхий үнэлгээний аль нэгийг өгнө.

а/90-100 оноо “Маш сайн”

б/80-89 оноо “Сайн”

в/70-79 оноо “Хангалттай”

г/60-69 оноо “Дутагдалтай”

д/0-59 оноо “Хангалтгүй”

Зургаа.Хяналт, шалгалтын үр дүнг тайлагнах

Хяналт, шалгалтын ажлын үр дүн, танилцуулгыг ажлын хэсэг нэгтгэн, хяналт шалгалтын дүнд үндэслэн авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг газрын дарга, удирдлагуудад 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр илтгэх хуудсаар танилцуулна.

Долоо.Үйл ажиллагааг үнэлж дүгнэх чиглэл, шалгуур үзүүлэлт

№	Баримт бичиг, шалгах үзүүлэлт	Шалгах ажилтан	Үнэлгээ	Тайлбар
I.Хууль, тогтоомж дүрэм журмын чиглэлээр				
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль	Ю.Хүслэн		
2	Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/93 дугаар захирамжаар баталсан	Ю.Хүслэн		

3	Газрын даргын А/14 дүгээр тушаалаар баталсан "Газрын дотоод журам"	Ю.Хүслэн		
4	Газрын даргын 2019 оны А/20 дугаар тушаалаар баталсан "Газрын ёс зүйн дүрэм"	Ю.Хүслэн		
5	"Ажилтан албан хаагчдын ажлын үр дүн, ур чадвар, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх журам"	Ю.Хүслэн		
6	Газрын даргын 2019 оны А/19 дүгээр тушаалаар баталсан "Ажлын хувцас, хэрэгсэл ашиглалтын журам"	Ю.Хүслэн		
7	"Эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"	Ю.Хүслэн		
8	Газрын даргын 2021 оны А/09 дүгээр тушаалаар баталсан "Нөөц түлхүүр байршуулах, хүлээлцэх журам" хэрэгжилт	Ю.Хүслэн		
9	Газрын даргын 2022 оны А/61 дүгээр тушаалаар баталсан "Хяналтын камерын төхөөрөмж байршуулах, ашиглах журам" хэрэгжилт	Ю.Хүслэн		
10	Газрын даргын 2022 оны А/60 дугаар тушаалаар баталсан "Хурлын заал, хуралдааны танхим ашиглах журам" хэрэгжилт	Ю.Хүслэн		
Хэсгийн дундаж хувь				
II.Хүний нөөцийн чиглэлээр				
11	Албан хаагчдын мэдээлэл, судалгаа /Шинэчилсэн/	Т.Азжаргал		
12	Хариуцсан байрны талаарх товч мэдээлэл /м ² , үйл ажиллагаа явуулж буй байгууллага, албан хаагчийн тоон судалгаа/	Т.Азжаргал		
13	Ажил хүлээлцсэн акт	Т.Азжаргал		
14	Ажилчдын цагийн бүртгэл	Т.Азжаргал		
15	Дотооддоо шинээр санаачлан хэрэгжүүлсэн бүтээлч ажил, арга хэмжээ, сайн туршлага	Т.Азжаргал		
16	Ажлын байрны эмх цэгц, ажилчдын хувцас хэрэгслийг журмын дагуу өмссөн байдал	Т.Азжаргал		
Хэсгийн дундаж хувь				
III.Төсөв, санхүүгийн чиглэлээр				
17	Өмч хөрөнгийн жагсаалт, бүртгэл	Б.Бямбаа		
18	Цэвэрлэгээний бараа материалын захиалгийн жагсаалт, хүлээн авсан, зарцуулсан тухай бүртгэл	Б.Бямбаа		
Хэсгийн дундаж хувь				
IV.ХАБЭА, Стандарт норм норватив, хэрэгжүүлж буй байдал				
19	Газрын даргын 2019 оны А/18 дугаар тушаалаар баталсан "Ажлын байрны цэвэрлэгээ үйлчилгээ, үйлчилгээний ерөнхий шаардлага" /НҮГ-01:2019/	Б.Жаргалсайхан		
20	Газрын даргын 2021 оны А/10 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага"	Б.Жаргалсайхан		
21	Ариутгал, халдваргүйжүүлэлтийн бүртгэл	Б.Жаргалсайхан		

22	Хувийн хамгаалах хэрэгслийн хүрэлцээ, хэрэглэж хэвшсэн байдал	Б.Жаргалсайхан		
Хэсгийн дундаж хувь				
V.Төлөвлөгөө тайлан, батлагдсан хуваарийг хэрэгжүүлж ажиллах чиглэлээр				
23	Гүйцэтгэлийн тайлан, төлөвлөгөө	Т.Азжаргал		
24	Үйл ажиллагааны тайлан	Т.Азжаргал		
25	Цаг үеийн шинж чанартай зохион байгуулагдсан ажлын тайлан	Т.Азжаргал		
26	Ажилчдыг үнэлсэн хуудас	Т.Азжаргал		
27	Их цэвэрлэгээ, ариутгалын хуваарь	Т.Азжаргал		
28	Дундын жижүүрийн хуваарь	Т.Азжаргал		
29	Өдөр тутмын цэвэрлэгээ хийсэн тэмдэглэл	Т.Азжаргал		
30	Цэвэрлэгээ, үйлчилгээг шалгах хяналтын хуудас	Т.Азжаргал		
31	Хамт олны хурлын тэмдэглэл, үүрэг даалгаврын хэрэгжилт	Т.Азжаргал		
32	Шинээр ажилд орсон ажилтанд анхан шатны цэвэрлэгээ, үйлчилгээний заавар зөвлөгөө өгч, удирдан зохион байгуулсан байдал	Т.Азжаргал		
Хэсгийн дундаж хувь				
VI.Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах чиглэлээр				
33	Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөө,	Б.Батсүрэн		
34	Өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний хэрэгжилт	Б.Батсүрэн		
35	Инженерийн шугам сүлжээний график үзлэгийн хуудас	Б.Батсүрэн		
Хэсгийн дундаж хувь				